

# БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН МОНИТОРИНГ ДҮНГИЙН ТАЛААР

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА А.ЭНХБАТ

12.20.2018

# АГУУЛГА

- 1. Байгаль орчны аудитын үүсэл, ерөнхий ойлголт, үйл явц;**
- 2. Байгаль орчны аудитын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн талаар**



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



## **БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ**

**1970-аад оны сүүл, 1980-аад оны эхээр АНУ-ын хувийн хэвшлийн үйлдвэрүүд анх ашиглаж эхэлсэн.**

**Үүний дараагаас Европын холбоо, Австрали зэрэг улсуудад нэвтрүүлсэн.**

**Австрали, АНУ, Европын холбоо зэрэг хөгжилтэй орнууд болон Уганда зэрэг хөгжиж буй орнууд үндэсний хууль тогтоомжоо баталж гаргасан байна.**



## МОНГОЛ УЛСАД:

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль /2012 он/;**
- **Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-126 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”;**
- **“Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”;**




## БОА-ЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

### Байгаль орчны аудит нь:

- Тухайн байгууллагын байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах;
- Үйлдвэр, ААНБ-ын экологи-эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх;
- Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад төсөл хэрэгжүүлэгчид туслах;
- Учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.

# МОНГОЛ УЛСАД БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫГ НЭВТРҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ



## БОА-ЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ЗОРИЛГО

1. Аймгийн БОАЖГ, уул уурхай, газрын тосны олборлолтын төсөл хэрэгжүүлэгч нарт БОА-ын хууль тогтоомж, арга зүй, олон улсын туршлагын талаар танилцуулах сургалт хийх;
2. Байгаль орчны аудит хийгдсэн Уул уурхайн төслийн талбайд газар дээр нь Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах, зөвлөмж өгөх;
3. БОА-ийн асуудлыг зохицуулж буй хууль, журам, аргачлал болон аудитын үйл явцтай холбогдох асуудлаар оролцогч талуудын тулгамдсан асуудлыг сонсч, хууль тогтоомжийг цаашид сайжруулах саналыг авах.

## БОА-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу **Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар** аймагт уул уурхай, газрын тосны олборлолтын үйл ажиллагаа эрхэлж ААНБ-ын 7 төсөлд хийсэн Байгаль орчны аудит, түүний зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийсэн.

### **Ажлын хэсэгт:**

- БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс;
- Аймгийн БОАЖГ-ын удирдлага, мэргэжилтнүүд;
- “СЕСМИМ” төслийн удирдлага, зөвлөхүүд;
- Байгаль орчны мэргэшсэн “Аудитор”-ын төлөөлөлтэй ажилласан.



## ХАМРАГДСАН ТӨСЛҮҮД

### Сэлэнгэ аймаг:

1. “Бороо Гоулд” ХХК-ний алтны үндсэн орд ашиглах Бороогийн ил уурхай, баяжуулах үйлдвэр;
2. “Болд Төмөр ерөө Гол” ХХК-ийн төмрийн хүдэр ашиглах Баянголын уурхай;
3. “Тод ундарга” ХХК-ийн алтны шороон орд ашиглах Нэргүй Хөндий ил уурхай;

### Дорнод аймаг

1. “Шинь Шинь” ХХК-ний Улааны холимог металын ордыг ашиглах далд уурхай, баяжуулах үйлдвэр;
2. “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК -ийн бүтээгдэхүүн хуваах гэрээт ХХI-р талбайд газрын тос олборлох төсөл;


### Сүхбаатар аймаг:

1. “Цайрт Минералс” ХХК-ийн Төмөртийн овооны цайрын ордыг ашиглах ил уурхай, уулын баяжуулах үйлдвэр;
2. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Хунт Өгөөж” ХХК-ийн жоншны далд уурхай;

## Ажлын хэсэг Сэлэнгэ аймагт



## Ажлын хэсэг Дорнод, Сүхбаатар аймагт



# БОА-ЫН МОНИТОРИНГИЙН ҮР ДҮНГЭЭС /БОДИТ БАЙДАЛ/

## Сайн тал:

- Байгаль орчны аудитыг хуулийн хугацаанд тогтмол хийх үүрэг, аудитын ач холбогдлыг бүрэн ойлгосон-(2/7)
- БОА-ын зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажилладаг-(4/7)
- БОА-ын эрх бүхий ААН-ийн аудитуудаасаа илүү чадавх, туршлагатай-(2/7)
- БОА хийлгэснээр тухайн уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн үйл ажиллагаад дэвшил гарсан-(2/7)

## Сул тал:

- БОА-ыг захиалан гүйцэтгүүлэх байгууллагыг сонгох, Ажлын даалгавар боловсруулах чадавх сул-(7/7)
- БОА-ын зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлээгүй-(7/7)
- БОА-ын тайлангийн нууцлалын талаар тодорхой ойлголт дутмаг-(7/7)
- Хуулийн дагуу БОА-ыг захиалан гүйцэтгүүлсэн хэдий ч тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ашиглаагүй, ач холбогдлыг бүрэн ойлгоогүй-(5/7)

# БОА-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

## /АСУУДАЛ/

1. Аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд, уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч ААН-үүдийн мэргэжилтнүүд БОА-ын холбогдох хууль, тогтоомжийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг;
2. Байгаль орчны аудитын холбогдох хууль, журмыг байгалийн нөөц баялаг ашиглагч аж ахуй нэгжүүд ижил түвшинд дагаж мөрдөхгүй;
3. Байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ажлын гүйцэтгэл хангалтгүй, тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлж хэвшээгүй;
4. БОА-ын тайланг төрийн хяналт шалгалтын үед үзүүлэх бичиг баримтын бүрдлийн түвшинд ойлгох;
5. Байгаль орчны аудитын байгууллагууд тухайн аудитын ач холбогдол, хэрэглээ, зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнах, нууцлалыг ямар түвшинд хангах зэргээр төсөл хэрэгжүүлэгчид бүрэн гүйцэд үйлчилгээ үзүүлээгүй;
6. Байгаль орчны аудитын журам, аргачлалд заасан шаардлагын дагуу аудит хийхэд гүйцэтгэх үе шатуудыг бүрэн гүйцэтгээгүй.

## ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Байгаль орчны аудитыг захиалагч, гүйцэтгэгч, түүнчлэн хэрэгжилтийг нь хангуулах эрх бүхий төрийн захиргааны байгууллага тус бүрийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулж, холбогдох хууль, эрх зүйн баримтад тусгах;

2. Төсөл хэрэгжүүлэгч нар “Байгаль орчны аудит” хийх гүйцэтгэгчийг сонгохдоо тухайн байгууллагын туршлага, аудиторуудын мэдлэг, ур чадвар, ёс зүйн зөрчилтэй эсэхийг сайтар нягталж байх,

3. БОА-аар өгсөн зөвлөмж, үл нийцлийг арилгах арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлж хэвших, аймгийн БОАЖГ тайланг хүлээн авч, хамтран ажиллах талаар санаачлагатай ажиллах;

4. Байгаль орчны аудитын ач холбогдол, нэр хүндийг өргөх талаар аудит хийж буй байгууллага, аудиторууд хариуцлагатай ажиллах;

5. Байгаль орчны аудитын тайлан, дүгнэлтээр хангалттай дүгнэгдсэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг хэрхэн урамшуулах, дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллагуудтай харилцан тохиролцож, шийдлийг тодорхойлох;

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.